



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/1272

Мандалговь

Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Залуус-2-229 тоот) байршилтай Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар (РД:9033556)-ын 252 м<sup>2</sup> (0.02га) газар дээр 3 давхар 24 айлын нийтийн орон сууц барьсан тул, 111600733 нэгж талбарын дугаартай газар эзэмших эрхийг дуусгавар болгож нийтийн эдэлбэрийн газар болгосугай.

2. Дээрх иргэний газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2014 оны А/137 дугаар захирамжийн Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар -т холбогдох хэсэг мөн газар эзэмших (000303464) тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111003